Улсын ерөнхий прокурорын 2026 оны
06 дугаар сарын 09-ний өдрийн
А / 95 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

√	Прокурорын байгууллагын бүтцийг шинэчлэн батлсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль 2017-12-07
Дагаж мөрдөх огноо:	2019-01-01
Албан тушаалын тодорхойлолтыг батлсан огноо:	2026-06-09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Улсын ерөнхий прокурорын газар	Хүний эрхийн бодлогын газрын Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хэлтэс
Албан тушаалын нэр:	**Албан тушаалын ангилал, зэрэглэл:**
Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хэлтсийн дарга, ахлах прокурор	Төрийн тусгай
Ажлын цаг:	**Ажлын байрны албан ёсны байршил:**
Ажлын өдрийн 8 цаг	Чингэлтэй дүүрэг 4 дүгээр хороо, Бага тойруу, Хуульчдын гудамж, 15/1
Хөдөлмөрийн нөхцөл:	**Онцгой нөхцөл:**
Хэвийн	**Хамаарахгүй**

II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, хяналт тавих, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ажлыг зохион байгуулах, нэгж прокурорын газрыг мэргэжлийн удирдлагаар хангах.

Албан тушаалын зорилт:

1.Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, нэгж прокурорын газрыг мэргэжлийн удирдлагаар хангах;

2.Төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох ажлыг зохион байгуулах;

3.Прокурор, ажилтныг өдөр тутмын удирдлагаар хангаж, гүйцэтгэлд хяналт тавих.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.1.Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлоход дэмжлэг үзүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах, биелэлт, үр дүнг үнэлж дүгнэх.	Бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээ авсан байна.	Т, Г, Х
	1.2.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд санал боловсруулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.	Төлөвлөлтийг оновчтой хийж, биелэлтийг хангуулсан байна.	Г, Х
	1.3.Улсын ерөнхий прокуророос Улсын Их Хуралд эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар хийх мэдээлэл, түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, Улсын дээд шүүхтэй харилцах чиглэлээр гаргах санал, дүгнэлт, тайлбарын төслийг боловсруулж, танилцуулах.	Үндэслэл бүхий мэдээлэл, санал, дүгнэлт, тайлбарын төсөл боловсруулсан байна.	Г
	1.4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Үндсэн хуулийн цэц, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад байгууллагаас ирүүлсэн хууль, дүрэм, журам, зааврын төсөлтэй танилцаж санал боловсруулах.	Үндэслэл бүхий саналын төсөл боловсруулсан байна.	Г, Х
	1.5.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар прокурорын байгууллагаас хүргүүлж буй тайлан, мэдээ, мэдээллийг боловсруулах.	Холбогдох мэдээллийг үндэслэл бүхий боловсруулсан байна.	Г
	1.6.Газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, ажлын бодлого, зорилтыг уялдуулах.	Ажлын уялдаа холбоог хангасан байна.	Г
	1.7.Иргэн, захиргааны хэргийн хяналтын шатны шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, хууль хэрэглээ тогтоосон шийдвэрийн талаар нэгж, прокурорын газарт хүргүүлэх мэдээлэл, зөвлөмж, албан бичгийн төсөл боловсруулах.	Төслийг боловсруулж, танилцуулсан байна.	Г, Х

	1.8.Иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор оролцоход үүсэж буй хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэх талаар санал гаргаж, танилцуулах.	Санал гаргаж, танилцуулсан байна.	Г, Х
	1.9.Хариуцсан ажлын чиглэлээр нэгж прокурорын газар, бусад байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийг судалж, танилцуулах.	Санал, хүсэлтийг судалж, танилцуулсан байна.	Г, Х
	1.10.Прокурор иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох чиг үүргийг хэрэгжүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангаж, холбогдох арга хэмжээ авах.	Мэргэжлийн удирдлагаар хангаж холбогдох арга хэмжээ авсан байна.	Г, Х
	1.11.Нэгж прокурорын газарт хугацаатай үүрэг, даалгавар өгч, биелэлтэд хяналт тавих.	Үндэслэл бүхий үүрэг даалгавар өгч, үр дүнг тооцсон байна.	Г, Х
	1.12.Эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийг дангаараа болон бусад газар, хэлтэстэй хамтран шалгах, судлах ажлыг зохион байгуулах, биелэлт, үр дүнг тооцох.	Шалгалт, судалгаа, танилцах ажил үр дүнтэй хийгдсэн байна.	Г, Х
	1.13.Дээд шатны прокуророос шилжүүлсэн иргэн, хуулийн этгээдийн өргөдлийг хянаж, танилцуулах.	Өргөдлийг хянаж, танилцуулсан байна.	Г, Х
	1.14.Хариуцсан ажлын мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал танилцуулах, биелэлт, үр дүнг тооцох.	Мэдээ, тайланд дүн шинжилгээ хийж, ажил, арга хэмжээний санал гаргасан байна.	Г, Х
	1.15.Прокурорын байгууллагын цахим бүртгэлийн нэгдсэн систем дэх чиг үүрэгт хамаарах бүртгэл хөтлөлтөд хяналт тавих, боловсронгуй болгох арга хэмжээ авах.	Бүртгэл бүрэн хөтлөгдөж, мэдээ гарах нөхцөл бүрдсэн байна.	Г, Х
	1.16.Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээг олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авах.	Олон нийтэд мэдээлсэн байна.	Г, Х
	1.17.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нараас өгсөн үүргийг хэрэгжүүлэх.	Үүрэг, даалгаврыг хэрэгжүүлсэн байна.	Г
	1.18.Хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан заавар, журам, Улсын ерөнхий прокурорын	Хууль, заавар, журамд заасан чиг үүрэг	Г

	тушаалаар хариуцуулсан чиг үүргийг хэрэгжүүлэх.	хэрэгжсэн байна.	
2 дугаар зорилтын хүрээнд	2.1.Төр, нийтийн ашиг сонирхолд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж, холбогдох арга хэмжээ авах.	Ажил, арга хэмжээ хамтран хэрэгжүүлсэн байна.	Г, Х
	2.2.Төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагаас гаргасан хүсэлтээр, эсхүл өөрийн санаачилгаар иргэн, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, ажлыг нэгтгэн зохион байгуулах.	Зохион байгуулалтаар хангасан байна.	Г, Х
	2.3.Иргэн, захиргааны хэрэг маргааныг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэртэй танилцах, гомдол гаргах.	Прокурорын гомдол хууль зүйн үндэслэлтэй байна.	Г, Х
	2.4.Нэгж прокурорын газраас прокурор оролцсон иргэн, захиргааны хэргийн анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэрт Улсын дээд шүүхэд гомдол гаргасан тохиолдолд шүүх хуралдаанд оролцох ажлыг зохион байгуулах.	Шүүх хуралдаанд прокурор оролцсон байна.	Г, Х
	2.5.Төр, нийтийн ашиг сонирхол зөрчигдсөн эрүүгийн болон зөрчлийн хэрэгт нэхэмжлэл гаргах эсэхийг судалж, холбогдох арга хэмжээ авах.	Зохион байгуулалтын арга хэмжээ авсан байна.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	3.1.Газрын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын биелэлт, үр дүнг тооцох.	Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулсан байна.	Г
	3.2.Хэлтсийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүртгэл, судалгааг хөтлүүлж, хяналт тавих.	Бүртгэл хөтлөлтөд хяналт тавьсан байна.	Г, Х
	3.3.Архив, албан хэрэг хөтлөлтийн ажиллагаанд холбогдох хууль тогтоомж, заавар, журам, стандартын хэрэгжилтийг хангах.	Хэрэгжилтийг хангасан байна.	Г, Х
	3.4.Дээд шатны прокурорын томилсноор газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэх.	Газрын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөл хангагдсан байна.	Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй		
Мэргэжил	Эрх зүй (0421)		

Мэргэшил	-хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн гэрчилгээтэй байх -хуульчийн багц цагийн сургалтад хамрагдсан байх	
Туршлага	Прокуророор 5-аас доошгүй жил, үүнээс Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор, Нийслэлийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч, ахлах прокурор, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, аймаг, тээвэр, дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурор, ерөнхий прокурорын орлогчоор 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	-хэлтсийн үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх; -прокурор, ажилтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; -эрсдлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх.
	Дүн шинжилгээ хийх	-мэдээллийг цуглуулж, шалган нягтлах; -шийдвэрийн үр дагавар, эрсдлийг үнэлэх; -судалгааны арга зүйг ашиглан санал, дүгнэлт боловсруулах.
	Асуудал шийдвэрлэх	-хариуцсан ажлын явцад үүссэн асуудал, хүндрэл бэрхшээлийн шалтгаан, нөхцөлийг бодит мэдээлэлд үндэслэн тогтоох; -шийдвэрийн үр дагавар эрсдлийг урьдчилан тооцоолох; -хууль тогтоомжид нийцсэн оновчтой шийдвэр гаргах; -гаргасан шийдвэрийн хариуцлагыг хүлээх.
	Манлайлах	-прокурор, ажилтнуудыг үлгэрлэн манлайлах; -ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх; -шинэ санаачилга болон өөрчлөлтийг дэмжих.
	Багаар ажиллах	-хамтын шийдвэр гаргалтад идэвхтэй оролцох; -хариуцсан ажлыг багийн зорилготой уялдуулан хэрэгжүүлэх; -мэдээллийг нээлттэй хуваалцах; -бусдын санал бодлыг хүндэтгэх.
	Бусад	-баримт бичиг боловсруулах; -хууль хэрэглэх; -ажлын ачааллыг оновчтой төлөвлөж, эрэмбэлэн зохион байгуулах; -албан хэрэгцээнд шаардлагатай мэдээллийн систем, программ хангамжийг ашиглах, мэдээллийг цахим орчинд боловсруулах.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хүний эрхийн бодлогын газрын дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:	Бусад харилцах субъект:
1. Хэлтсийн хяналтын прокурор 2. Газар, хэлтсийн туслах ажилтан 3. Аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор 4. Аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын хүний эрх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах ажил хариуцсан прокурор	1.Нэгж прокурорын газрын прокурор, ажилтан 2.Шүүх 3.Бусад төрийн байгууллага 4.Иргэн, хуулийн этгээд

5. Сум дундын прокурорын газрын хяналтын прокурор Нийт: 5	
V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:
Албан тушаал: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ТУСЛАХ ПРОКУРОР, БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХТУЯА 2026 оны 05 дугаар сарын 29-ний өдөр	Байгууллагын нэр: УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ДЭРГЭДЭХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдөр Дугаар: 2
Албан тушаалын тодорхойлолт батлсан:	
Байгууллагын нэр: МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Дугаар: А/95 УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН ТЭРГҮҮН ЗӨВЛӨХ Б.ЖАРГАЛСАЙХАН 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдөр	